МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,110.230... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.10.14. Баасан. №184 (4554) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

ХОЙД ЗҮГТ ТАВЬСАН ИХ ӨРИЙН САЛХИ УРД ЗҮГЭЭС ҮРГЭЛЖИЛНЭ

II нүүрт

ДЭЛХИЙ

ГАИТИД 450 ГАРУЙ ХҮН АМИА АЛДЛАА

VI нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## Өвдөхөөсөө өмнө өөрийгөө хайрлаач

Н.БАТЗАЯА

Сүүлийн үед хэн нэгний эмчилгээний зардалд зориулсан хандивын тоглолт, сайн үйлсийн аян цахим ертөнцөд энгийн үзэгдэл боллоо. Тодруулбал, элэг солиулох хагалгаа, тархины хорт хавдар, бүдүүн гэдэсний архаг шархлаат үрэвслээр өвчилсөн тул халуун сэтгэлээ сунгаж тусална уу хэмээн хэн нэгний эмчилгээний зардалд зориулсан постууд олширсон. Тэр бүү хэл бага насны хүүхэд хүртэл хорт хадвар тусч, хэн нэгнээс тусламж гуйх болов. Хүнд өвчин хэлж ирдэггүй хийсч ирдэг гэдэг. Гэхдээ монголчууд хэлж ирдэггүй гэдэг ганцхан үгээр өөрсдийгөө хаацайлж, өдийг хүрлээ. Улс орон хөгжихийн хэрээр эмнэлгийн үйлчилгээ сайжирч байгаа энэ цагт "Төр л намайг эмчлэх ёстой. Төр миний эрүүл мэндийн төлөө юу ч хийхгүй байна" гэсэн жалга довны үзлээсээ салах цаг нэгэнт болжээ.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

Ж.ОТГОН

*Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийн асуудал, хотыг удирдах мандат авсан Су.Батболдын тэргүүлсэн удирдлагууд ажилдаа ороод 100 хоногт юу хийсэн, Мэргэжлийн Засгийн газрын 100 хоногт сөрөг хүчин ямар дүн тавьсан, Тэтгэвэр, тэтгэмжийг өөрчлөх хуулийн төсөл зэрэг асуудал энэ долоо хоногийн гол сэдэв байлаа. Тиймээс "Монголын мэдээ" сонин "Хэн юу хэлэв" булангаараа дээрх сэдвүүдийг онцолж, хэн юу хэлсэн талаар хүргэж байна.*



### М.Мөнхбаатар: "Эрдэнэт"–ийн худалдан авалтад төр хэт оролцох нь хөрөнгө оруулалтыг үргээнэ

*"Монголын зэс" корпорацийн ТУЗ-ийн дарга/*

-Оросын талын 49 хувийг "Монголын зэс" гэж үндэсний компани худалдаж авснаар 43 жилийн дараа "Эрдэнэт" үйлдвэр 100 хувь Монгол Улсын, монголчуудын мэдэлд ирж байгаа юм. Нэг зүйлийг зориуд онцолж хэлэхэд Монгол Улсын Засгийн газрын эзэмшиж байсан 51 хувьд огт өөрчлөлт ороогүй, төрийн мэдэлд хэвээрээ байгаа. Харин бид Оросын талын эзэмшиж байсан 49 хувийг худалдаж авсан. Энэ бол нэг хүний хувьцааг нөгөө нь худалдаж авсан, санхүүгийн зах зээл дээр өдөр бүр л болдог энгийн процесс. Улс орны өнөөгийн эдийн засгийн байдал, нөөц бололцоог харахад 49 хувиа худалдаж авна гэдэг нь эргэлзээтэй байна. Ер нь одоо байгаа 51 хувиа нэмэгдүүлж 100 хувь болгоно гэдэг нь аль ч төр, засгийн үеийн бодлого биш байлгүй дээ. Засгийн газар хоорондын гэрээ болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр Оросын тал 49 хувиа худалдаж авахыг эхлээд Монгол Улсын Засгийн газарт санал болгоно. Хэрвээ Монгол Улсын Засгийн газар худалдаж авахгүй гэвэл гуравдагч этгээдэд санал болгох ёстой. Энэ бүх процесс болсны дараа бид хувьцаа худалдаж авах өрсөлдөөнд оролцох эрхтэй болсон. Түүнээс бус, Монгол Улсын Засгийн газар худалдаж авах, эс саналаа илэрхийлээгүй байхад, эсвэл Засгийн газар худалдаж авна гээд байхад бид өмнүүр нь ороогүй. Хууль эрх зүйн хувьд тийм боломж ч байхгүй. Манай Улсын Засгийн газар худалдаж авахгүй гэдэг байр сууриа илэрхийлсэн, тэрнийх нь дараа Хятадын болон Казахстаны компаниудтай хамт манай компани хувьцаа худалдаж авах өрсөлдөөнд оролцсон. Ер нь "Эрдэнэт"-ийн 49 хувийг тойрсон үйл явдал дээр заавал буруутан гаргаж ирэх гээд байгаа бол миний бодлоор тэр нь хувьцаагаа зарсан Оросын тал. Хүн өмчөө зарах, үгүй нь өөрийн л мэдэх хэрэг. Тэр байтугай, хэнд зарахаа өмчийн эзэн мэддэг. Энгийн амьдрал дээр ч ийм дүрэм үйлчилдэг. Хувьцаагаа зарлаа гэж оросуудыг буруутгавал бид л инээдтэй харагдана. Ер нь "Эрдэнэт" үйлдвэрийн хувьцаа худалдан авалт тойрсон энэ үйл явдалд төр ингэж хэт оролцох нь хөрөнгө оруулалтыг үргээнэ.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ХҮМҮҮС



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ДАВААХҮҮ

*Амьдралынхаа 60 гаруй жилийг боловсролын салбарт зориулж, түмэн олноо "Цагаан толгой"-н гэх тодотголоор танигдсан МУБИС-ийн хүндэт профессор, зөвлөх багш Г.Лхаахүүг "Хүмүүс" буландаа урьж ярилцлаа.*

## Г.ЛХААХҮҮ: БОЛОВСРОЛЫН САЛБАРТ АМЬДРАЛЫНХАА 60 ГАРУЙ ЖИЛИЙГ ЗОРИУЛЖ ЯВНА

**-Та аль нутгийн хүн бэ. Ээж, аав тань ямар хүмүүс байв. Бага насны он жилүүдийн тань дурсамжаас хоёулаа ярилцлагаа эхлэх үү?**

-Хуучнаар Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошуу, одоогийн Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын уугуул. Миний эцэг эх ном судрыг хүндэтгэдэг, номын хүмүүс байлаа. Бага насандаа таван хошуу мал сүргийн эгшиглэнт дуу, байгалийн уянгалаг чимээ, аав ээжийн орой маани хөгжөөх дуунд өсч торнисон. Аав минь номтой, түвд бичиг үсэг мэддэг малчин хүн байж билээ. Тэр үед яаж ном эрдэм сурсан байсныг нь мэдэхгүй юм.

**Төгсгөл нь IV-V нүүрт**

ROYAL IRISH PUB
7 ЖИЛИЙН ОЙН БАЯР

ROYAL GRILL
RESTAURANT



ROYAL BEER FESTIVAL 2016
10.20-10.28 дуустал

Шинэ ургацын шар айраг
Хамтлаг дуучдын тоглолт
Сонирхолтой олон уралдаан тэмцээнүүд

**Урилгаар**
**- Koln хамтлаг**
**- Гитар уйлуулагч Гантулга**
**- RecOn хамтлаг**
**- Madness хамтлаг**
**- Дуучин БоБо хамтлагтайгаа болон бусад хамтлаг дуучид, олон төрлийн сюрприз, сонирхолтой уралдаан тэмцээнүүд үдэш бүр таныг хүлээж байна.**

**Шинэ рестораны нээлтийн хямдралд БҮХ ХООЛ 7000₮ болон хямдарлаа.**

ЗАХИАЛГА АВАХ УТАС 9903-4188



**Хаяг: БЗД, 13-р хороолол, зүүн дөрвөн зам уруудаад Royal House зочид буудлын 1 давхарт**
**ROYAL IRISH PUB**



**3-р хороолол Өргөө Номингийн хойморьт Роял хоус Зочид буудлын 2 давхарт**
**ROYAL GRILL RESTAURANT**

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

18 дахь жилдээ МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

Улиралд 44 дугаар

захиалгын үнэ 15600

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2278.00 | 2295.00 | ФУНТ | 2734.00 | 2832.00 | АМ.ДОЛЛАР | 2280.00 | 2295.00 | ФУНТ | 2742.00 | 2828.00 |
| ЕВРО | 2486.00 | 2554.00 | РУБЛЬ | 34.70 | 37.70 | ЕВРО | 2481.00 | 2559.00 | РУБЛЬ | 34.89 | 38.11 |
| ИЕН | 21.75 | 22.33 | ЮАНЬ | 337.50 | 342.90 | ИЕН | 21.69 | 22.44 | ЮАНЬ | 338.00 | 343.10 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Намын харьяаллаар ажлаас нь халаагүй гэв

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн 105 ажилтныг хоморголон халсан гэх асуудлаар Сангийн яамнаас мэдээлэл хийлээ. Хуралд Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын дарга Б.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга М.Нарангэрэл тэргүүтэй хүмүүс оролцсон юм. “Тогтвортой амьжиргаа-3” гэх төслийг Дэлхийн банк болон Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 21 аймагт Сангийн яамнаас хэрэгжүүлж иржээ. Энэ төсөлд ажиллаж байгаад хууль бусаар халагдсан гэх ажилтнуудын төлөөлөл мэдээлэл хийж, өөрсдийг нь намын харьяаллаар хууль бусаар халсан гэсэн юм. Тэгвэл энэ мэдээллийг өнөөдөр Сангийн яамнаас ташаа хэмээн, залруулга хийж буйгаа мэдэгдсэн юм. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын дарга Б.Гантулга “Сангийн яам намын харьяаллаас үүдэн хууль бусаар ажилтнуудыг хоморголон халсан зүйл байхгүй. Энэхүү төслийн хүрээнд 21 аймгийн сум дэмжих багийн 105 ажилтныг зургаан сарын хугацаанд хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан. Энэ бол хөдөлмөрийн гэрээ биш. Тус хөлсөөр ажиллах гэрээнд сум дэмжих ажилтнуудын гэрээ 2016 оны есдүгээр сарын 30-нд дуусгавар болно гэж заасан. Энэ дагуу есдүгээр сарын 30-нд дууссан. Мөн тэдний зүгээс “Хөдөлмөрийн тухай хуулийн 40.5-д заасан 30 хоногийн өмнө гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлсэн байх заалт зөрчиж байна” гэсэн. Тухайн ажилтнуудтай зөвхөн хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулсан тул энэ заалтад хамаарахгүй.

# НЭР ДЭВШИГЧИД НИЙГМИЙН СҮЛЖЭЭГ СУРТАЛЧИЛГААНЫ ЧУХАЛ ИНДЭР БОЛГОН АШИГЛАЖЭЭ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.ОТГОН

УИХ болон НИТХ-ын сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааг Хэвлэлийн Хүрээлэнгээс танилцууллаа. Уг судалгааг Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн байна. Судалгаанд Монголын мэдээ, Зууны мэдээ, Өглөөний сонин, Өдрийн сонин, Өнөөдөр зэрэг өдөр тутмын болон долоо хоног тутмын зургаан сонин, iKon.mn, gogo.mn, news mn. medee.mn, 24tsag.mn гэсэн таван сайт, нэр дэвшигч болон сэтгүүлчдийн 24 фэйсбүүк аккаунт, 23 твиттер аккаунтыг хамруулжээ. Хугацааны хувьд сонгууль эхлэхээс 14 хоногийн өмнө эхэлж, сонгуулийн сурталчилгааны хугацаатай зэрэг дуусгасан байна. Энэ нь нийт 32 хоногийн мэдээлэлд мониторинг хийсэн гэсэн үг юм.

Судалгааны талаар Хэвлэлийн Хүрээлэнгийн гүйцэтгэх захирал М.Мөнхмандах “Энэ удаагийн мониторинг нь сонгуулийн сурталчилгааны өмнөх үеийг сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлсэн үеийн мэдээлэлтэй жишихээс гадна сонины мониторингийн дүнг 2012 оны үр дүнтэй харьцуулснаараа онцлог байсан. УИХ-ын 2012 оны сонгуулиар тогтмол хэвлэлүүд сонгуулийн сурталчилгаанд ихээхэн ач холбогдол өгч байсан бол 2016 оны сонгуулиар ил, далд хэлбэрийн сурталчилгаагаа багасгаж, сонгуулийн талаархи сэтгүүлзүйн бүтээлийн тоогоо нэмсэн. Түүнчлэн сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийн эзлэх хувийг өсгөсөн нь эерэг үр дүн байлаа” гэв. Энэ удаагийн сонгуулийн мэдээлэл, сурталчилгааны нэг онцлог нь намууд болон нэр дэвшигчид нийгмийн мэдээллийн сүлжээг сонгуулийн сурталчилгааны чухал индэр болгон ашигласан байна. Харин жижиг намууд болон бие даагчдын төлөөлөл твиттерийг илүүтэй ашиглаж байсан бол том намууд, ялангуяа АН фэйсбүүкт илүүтэй анхаарлаа хандуулан сонгуулийн сурталчилгаагаа хийсэн гэнэ. Түүнчлэн сонгуулийн үеэр хэвлэмэл сониноуд олон нийтэд мэдээлэх, танин мэдүүлэх үүргээ биелүүлэхэд түлхүү анхаарсан гэдгийг энэ үеэр онцолж байлаа. Харин цахим мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн мэдээллийн сүлжээ сурталчилгааны индэр байх үүргээ илүүтэй гүйцэтгэсэн байна.

Мониторингийн хүрээнд сонгуулийн сурталчилгааны өмнө болон сурталчилгааны үеэр олон нийтэд хүрсэн сонины 528 нэгж мэдээлэл, цахим сайтын 1998 нэгж мэдээлэлд анализ хийсэн бол нийгмийн мэдээллийн сүлжээний 926 жиргээ, 253 постыг цуглуулж, анализ хийсэн байна. Энэ талаар Судалгааны албаны дарга Г.Гүнждмаа “Сурталчилгааны бус үетэй харьцуулбал сонгуулийн албан ёсны сурталчилгаа эхэлснээр сонгуультай холбоотой мэдээлэл сонин болон нийгмийн мэдээллийн сүлжээнд хоёр дахин, цахим сайтад тав дахин өссөн. Сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө сонгуулийн тухай редакцийн буюу сэтгүүлзүйн бүтээл зонхилж байсан бол хуулийн дагуу албан ёсны сурталчилгаа эхэлснээр төлбөртэй сурталчилгааны тоо эрс нэмэгдсэн байсан. Сэтгүүлзүйн бичлэгийн төрөл зүйлээр бэлтгэсэн боловч редакцийн бүтээлээс ялгасан тэмдэглэгээгүй, олон нийтийн анхаарлыг татахын тулд тодорхой улстөрчийг илт дэмжсэн, сонгуульд өрсөлдөгч нэр дэвшигч эсвэл намын нэр хүндэд шууд халдсан “далд сурталчилгаа”-ны бүтээл улс төрийн сурталчилгааны 60-80 хувийг эзэлсэн” гэлээ. Харин цахим сайт болон хэвлэмэл сонины сонгуультай холбоотой мэдээллийн өнгө аяс нь тухайн мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьялал, редакцийн бодлоготой хамааралгүйгээр, гагцхүү төлбөр төлсөн этгээдийн захиалгаар тухайн мэдээллийн эерэг, сөрөг хандлага тодорхойлогдож байсан аж.

2016 оны УИХ болон НИТХ-ын сонгуулийн талаархи сөрөг мэдээлэл тогтмол хэвлэл болон цахим мэдээллийн хэрэгсэлд харьцангуй бага байсныг онцолж байв. Түүнчлэн нийгмийн мэдээллийн сүлжээний фэйсбүүк хуудсаар харьцангуй төвийг сахисан болон эерэг мэдээлэл цацагдсан бол твиттер хуудсанд сөрөг өнгө аястай, бүдүүлэг үг хэллэг ашигласан, өрсөлдөгч намуудыг гүтгэж доромжилсон мессэж түгээмэл байжээ.

Сонгуулийн талаархи мэдээллийн хандлагыг ажиглавал үндэсний хэмжээнд МАН-ын тухай эерэг, АН-ын тухай сөрөг мэдээлэл давамгайлсан бол нийслэлийн АН-ын тухай эерэг мэдээлэл илт давамгай байхад нийслэлийн МАН-ын тухай сөрөг мэдээлэл түлхүү гарч байсан байна. Харин сурталчилгааны сүүлийн өдрүүдэд АН-ын ялангуяа нийслэлийн АН-ын талаархи эерэг өнгө аястай далд сурталчилгаа хэвлэлийн хуудсаа зонхилжээ. Эмэгтэй нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр бодлогоор дэмжих, мэдээллийн хүйсийн тэнцвэрийг зориудаар хангах хандлага аль ч мэдээллийн хэрэгсэлд онцгойлон ажиглагдсангүй. Харин цаг үеийн үйл явдалтай холбоотойгоор мэдээлж, иш татах эсвэл тухайн эмэгтэй нэр дэвшигчийн захиалгат мэдээлэл (хөрөг, сурвалжлага, ярилцлага) нийтлэх нь түгээмэл байсан аж. Тухайлбал, “Монголын мэдээ” сонин эмэгтэй улстөрчдийн хөргийг цувралаар нийтлэж байсан хэмээн онцолсон юм.

ӨӨР ӨНЦӨГ

# ХОЙД ЗҮГТ ТАВЬСАН ИХ ӨРИЙН САЛХИ УРД ЗҮГЭЭС ҮРГЭЛЖИЛНЭ

Ж.ӨӨДЛӨН

БНМАУ ах дүүгийн ган бат найрамдалтай ЗСБНХУ-аас 20 жилийн хугацаатай зээл авч түүнийхээ хүүг 50 жилийн турш төлөөд ч цаана нь гарч амжилгүй байтал аз тохиож Ардчилалтай залгасны хүчинд “амь” мултарсан түүхтэй. Гэвч бид дэндүү эрт баярлачихаж. Хойд хөршид өр тавьж, түүнийхээ авлигад Давст уулаа хүртэл тавьж туусан тухайн үеийн МАХН-ын залуу халаа эдүгээгийн МАН зээл тавихаар урд хөршийг зорьжээ. Холбогдох албаны хүмүүс намын даргаа “МАН-ын дарга, УИХ-ын дарга М.Энхболд энэ сарын 14-17-ны өдрүүдэдБНХАУ-д албан ёсны айлчлал хийхээр өчигдөр Улаанбаатар хотоос мордлоо. Тэрбээр тус улсад ажиллах хугацаандаа Бээжин хотноо зохион байгуулагдаж байгаа Олон улсын улс төрийн намуудын чуулга уулзалтад оролцох юм” хэмээнхамгаалж байгаа ч чухамдаатус улсын коммунист намаас 20 жилийн хугацаатай мөнгө зээлэхээр хүлгийн жолоо залсан юмсанж. Зарим эх сурвалжийн мэдээлж буйгаас үзэхэд, зээл тусламжийн асуудал нэлээд хэдэн сарын өмнөөс яригдаж эхэлсэн бөгөөд холбогдох бичиг баримтыг нь ч бүрдүүлж дууссан, гэрээнд хоёр тал гарын үсэг зурах л үлдсэн гэнэ. Энэ талаар хэвлэлүүд “Энэ сарын эхээр буюу аравдугаар сарын 01-ний өдөр УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболд БНХАУ-ын Коммунист намын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын хорооны гишүүн, Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын газрын нарийн бичгийн дарга Лю Юньшанийг их жанжин Сүхбаатарын талбайд улаан хивс дэлгэн хүндэтгэн угтсан. МАН-ын дарга зочиндоо аяганы амсар зуулгах зуураа “Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байна. Тиймээс бидэнд үед урт хугацаатай хөнгөлөлттэй зээл тусламж өгөөч, свот гэрээний хугацааг сунгаач, орон сууцны ипотекийн зээлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлээч” хэмээн зовлон тоочиход Лю Юньшан “Монгол Улсад тулгараад байгаа эдийн засгийн хүндрэлийг даван туулахад шаардлагатай туслалцаа үзүүлэх, тодорхой зохицуулалт хийх боломжтой” гэчихээд нутаг буцсан нь таны тавьсан хүсэлтийг хүлээн авлаа. Нутагтаа очоод зохицуулж өгье” гэснээс ялгаагүй хэмээн онцолж байна.

Улсын эдийн засаг хямарсан энэ цаг үед асуудлыг шийдэх гарц нь урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл авах явдал байж болох ч хаяа залган орших хөршөө сонгох нь зөв шийдэл гэж би хувьдаа хэлэхгүй. Хойд хөрштэйгөө хэт ойр байж, ах дүүс болж давхисны горыг монголчууд үеийн үед мартахааргүйгээрээ амссан бус уу. Туурга тусгаар улсын дотоод хэрэгт хэний ч хамааралгүйгээр оролцож, мэдлэг боловсролтой, сэхээтнүүдийг маань толгой дараалан баривчилж, эх орноосоо урвасан ял тулган цаазалж орхисон гашуун түүх мартагдаагүй байна. Түүгээр ч зогсохгүй өнгөтэй өөдтэй бүхнийг минь өрөндөө суутгасан. Ийм эмгэнэлт амьдрал дахин давтагдвал яана. Азаар оросууд бидэнтэй тэгтлээ цус холилдож, биднийг уусгах бодлого баримтлаагүй. Нөгөөтэйгүүр, зээл авах, тусламж үзүүлэх нь хүний хорвоод байх л зүйл. Гагцхүү зээлийн хугацаа хэтэрвэл өр болж хувирна. Бас зээлд хүү гэж бий. Хугацаа хэтрэх аваас алданги тооцоод зогсохгүй хүүгийн хүү бодогддог. Энэ бол зах зээлийн хууль. Ингээд бодохоор бид хэдий ядарсан ч хөршийнхөө хаалгыг цохихгүй тойрох аваас хэтийн аюул холуур тойрч өнгөрч мэдэх юм. Харамсалтай нь, засгийн эрхийг барьж буй намын дарга маань “Хятадаас зээл авахаас өөр гарц бидэнд үлдээгүй”, “Хятадын банкийг оруулж ирнэ” хэмээн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагууддаа онцолж дурьдан, түүнийгээ дэлхийгээр нэг цацах болсон. Тэгээд ч урд хөрш маань өгч ч чаддаг, авч чаддаг үндэстэн.

Тажикистан улсад өгсөн зээлээ хэрхэн эргүүлж авсныг бид сонсч л байлаа. Хятадаас зээлсэн мөнгөө төлж чадахгүй газар нутгийнхаа зарим хэсгийг өгсөн шүү дээ. Бидэнд ийм зүйл тохиолдвол яана. Эдийн засаг сэргэхгүй бол яах юм. Өмнийн говио Давст уул шигээ тавьж туух хэрэг үү. Түүх давтагдахад ойрхон байна. Аюулын харанга дэлдээд эхэлчихлээ. УИХ дахь сөрөг хүчин ч энэ талаар дуугарч, байр сууриа илэрхийлэх болсон. Тухайлбал, УИХ дахь АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ “Уг нь энэ оны төсвийн алдагдал 4.3 их наяд байхаар төсөөлж байсан. Гэтэл одоо 3.4 орчим их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний гүйцэтгэлтэй байгаа. Одоо хаанаас дахиад нэг их наядыг алдагдал болгож харуулах гэж байгааг бид харж байна. Ер нь бол, алдагдал болгож харуулах, ямарваа нэг эрсдэлтэй болж харагдах бүх зүйлийг төсвийн алдагдалд бичиж байгаа. Алдагдал гэж харуулахыг хичээж, алдагдлыг 4.3 их наядад хүргэхээр чармайж байна” гэдгийг дуулгасан. Үүнээс үзэхэд “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдаж 1.5 тэрбум ам.долларыг, мөн 4.2 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний их мөнгийг ямар нэг эх үүсвэрээс оруулж ирэх магадлалтай болоод байна. Гэтэл энэ их мөнгийг юунд зарцуулах гэж байгаа юм, хаанаас оруулж ирэх гэж байгаа, гэдэг талаар ганц ч үг, үсэг төсвийн төсөл дээр болон МАН-ын зүгээс гаргаж буй бичиг баримт дээр байхгүй байгаа. Магадгүй их хэмжээний мөнгө орж ирэх нууц эх үүсвэр нь Хятад улс бололтой” хэмээн мэдэгдсэн. Тэгэхээр энэ нь хойд зүгт тавьсан их өрийн салхи урд зүгээс үргэлжилнэ гэсэн үг үү.

МЭДЭЭЛЭЛ




МАН-аас орон нутгийн сонгуультай холбоотой мэдээлэл хийлээ. Хэвлэлийн хуралд, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч Д.Амарбаясгалан нарын хүмүүс оролцлоо. МАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч Д.Амарбаясгалан “МАН олон бусармаг зүйлийг засч, залруулах олон төрлийн ажил хийж байгаа. Наад зах нь гадаад, дотоодын зээл тусламж, өрийг зориулалтын бусаар зарцуулсан хууль бус үйлдэл илэрсэн. Үүнийг залруулахын төлөө Засгийн газар ажиллаж байгаа. Тухайлбал, Чингис бондын зарцуулалтаар хийсэн шалгалтын үр дүнд 1.3 их наяд төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Засгийн газрын бодлогогүй үйл ажиллагаа, ажил хариуцаж байсан хүмүүсийн хууль бус үйлдэлтэй холбоотой гэж харагдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор МАН-аас хуулийн байгууллагад хандаж байгаа. Төсвийн тодотголоор өнгөрсөн оноос хойш олон нийтэд хүрэх ёстой байсан тэтгэвэр тэтгэмжийн асуудлыг шийдлээ. Үүний дунд оюутны 70 мянган төгрөгийн тэтгэмжийн асуудлаас эхлээд олон зүйлийг засч залруулж оруулж ирсэн. АН-ын зүгээс “МАН амлалтаас буцаж, мөрийн хөтөлбөрөөсөө ухарлаа” гэсэн мэдээлэл цацаж байна. Гэтэл МАН-ын мөрийн хөтөлбөрийг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 100 хувь тусгасан. Үүний хэрэгжилтийн үр дүнг 2020 оны сонгуулийн өмнө танилцуулна. АН-ынхан дараагийн дөрвөн жилд МАН-аас хэрэгжүүлж байгаа бүх ажлыг анхан шатны нэгжид гацаах зорилготой сурталчилгаа явуулж байгаад хамарсалтай байна. МАН иргэдийн цалинг хасах байдлаар асуудлыг шийдэх нь буруу, харин цалин тэтгэврийг үе шаттайгаар нэмэх шаардлагатай юм гэж үзэж байгаа. Ингэхийн тулд эдийн засгийг сэргээх арга зам авч байна.

Эдийн засгийн хүндрэлээс гарахын тулд нэгдүгээрт, Олон улсын валютын сангаас тусламж авах. Хоёрдугаарт, маш бага хүүтэй урт хугацааны хөгжлийн зээл авах. Гуравдугаарт, бондын хугацааг сунгах боломж бий. Гэхдээ бондын эргэн төлөлтийн хугацааг сунгах гэхээр хүүгийн хэмжээ нэмэгдэх асуудал бидний өмнө тулгарчхаад байна. Ерөнхий сайд, Сангийн сайд, Гадаад харилцааны сайд нар эдийн засгийн хүндрэлээс гарахын тулд албан айлчлал хийж, энэ асуудлаар ярилцаж байгаа. Дээрх гурван замын аль нэгийг сонгож эдийн засгийн хүндрэлээс гарна гэсэн байдлаар ажиллаж байна” гэлээ.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Ãàäíû óëñ îðíóóä èïîòåê, ìîðãåéæèéí çýýëýýð àðä èðãýäýý îðîí ñóóöòàé áîëãîñîí áàéäàã. Èïîòåêèéí çýýëä õàìðàãäñàí àæèëòàí òîãòâîð ñóóðüøèëòàé àæèëëàõ, àëü áîëîõ àæëûí áàéðàà õàäãàëæ ¿ëäýõ òàë äýýð àíõààð÷ àæèëëàäàã.

*Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн Ерөнхийлөгч*

*Д.Цэрэнжигмэд*

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

## Д.Баттулга: Су.Батболд би АСЕМ–ийг мэргэжлийн өндөр төвшинд хийж чадсан гэж хэлсэн

*/НИТХ-ын төлөөлөгч/*

-АН-ын буюу Э.Бат-Үүл даргын 100 хоног, Су.Батболдын 100 хоногийг харьцуулах боломж бүрдсэн байна. 2012 онд бид нийслэлд олонхи болоод олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. 2012 оны долдугаар сарын 9-нд анхны хурлаа хийсэн. Түүнээс хойш 20-хон хоногийн дараа зөвшөөрөлгүй барилгуудын ажлыг нь зогсоосон. Дарга нартай ойр дотно хүмүүс дур зоргоороо авирладаг байлаа. Наймдугаар сарын сүүлээр замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зарим арга хэмжээг авах тогтоолыг ИТХ-аас гаргаж байсан юм. Тэр үед одоогийн хэрэгжиж байгаа дугаарын хязгаарлалт, автобусыг нэгдүгээр эгнээгээр зорчуулах, сургуулийн хүүхдийн автобус, байгууллагын гаднах зогсоолын 70 хувийг чөлөөлж иргэдийн машиныг зогсоодог болгох, ажилчдын автобус гээд цогц арга хэмжээг авах тогтоолыг баталсан. Ингээд есдүгээр сарын 01-ээс хэрэгжүүлж байв. Бид НИТХ-ыг сар болгон хуралдуулж, байнгын ажиллагаатай болгож байсан үе. Мөн энэ үед газрын наймааг цэгцэлсэн. 2012 онд газрын мафи бий боллоо гэж ярьж байсан бол өнөөдөр алга болсон. Иргэд ямар байсныг хурдан мартдаг юм шиг байна. Бид 2012 оны есдүгээр сард Засаг даргын газар олгох эрхийг зогсоогоод, хэрэв газар олгох бол зөвхөн ИТХ-аар шийднэ гэдэг шийдвэрийг гаргаж байж газрын наймааны асуудлыг зогсоосон. Жилийн дараа Засаг даргад эрхийг нь өгч, Цахим газар олголт, ил тод газрыг олгох асуудлыг, төсөвт хөтөлбөрийн талаар олгоё, газар хувьчлалыг ил тод болгоё гэж газар олгох асуудлыг хуулийн дагуу болгосон юм. ИТХ-ыг телевизээр шууд дамжуулдаг болсон, Засаг даргын захирамж, шийдвэр 48 цагийн дотор иргэдэд www.ulaan-baatar.mn гэдэг сайтаар хүрдэг, ил тод болсон юм. Ингэж л эхний 100 хоногийг үдэж байсан. Миний ярьсан зүйлүүд бол зөвхөн гол гол зүйл. Үүнээс цааш иргэдээ сонсдог болсон гээд маш олон зүйл бий. Харин Су.Батболдын Засаг даргын ажлыг би ярихаар Баттулга харлуулж байна гэх байх л даа. Гэхдээ байгаа зүйлийг байгаагаар нь л хэлэх ёстой. Есдүгээр сарын сүүлээр ИТХ хуралдаж, Засаг даргын мөрийн хөтөлбөрийг авч хэлэлцлээ. Энэ үед би Су.Батболд даргаас, "Та эхний 100 хоногтоо хийсэн томоохон ажлаа нэрлээч" гэж асуусан. Тэгэхэд "Би АСЕМ-ийг мэргэжлийн өндөр төвшинд хийж чадсан" гэж хариулж байна билээ. Энэ бол хамгийн том ажил нь. АСЕМ-ийн бэлтгэл ажлыг хоёр жилийн өмнөөс Засгийн газар, хотын захиргаа хамтарч хийсэн юм шүү дээ. Тууз хайчилсан хүн тэр ажлыг өөртөө наадаг юм бол Батболдын зөв байх л даа. Өөр томоохон ажлыг нэрлэж үнэхээр чадаагүй. Тэр хурлыг зурагтаар шууд дамжуулсан, иргэд сонссон байлгүй дээ. Харамсалтай нь өөр олон зүйл дээр ухралт гарлаа, нийслэлд. Шилэн дансыг зогсоолоо, ИТХ-ын тэргүүлэгчдийн хурал бүгд хаалттай явдаг болсон. Нээлттэй засаглал хаалттай болчихлоо. Энэ бол хамгийн том ухралт. Хэн засаг барих нь хамаагүй, гол нь ямар ажил хийж байгаа нь нээлттэй л байх ёстой. Нөгөөтэйгүүр хотоос хийж хэрэгжүүлсэн бүх ажлууд зогсонги болчихлоо.

## О.Магнай: Ажил хийдэг биш зогсоодог Засгийн газар байгуулагдсан

*/ШӨХТГ-ын дарга асан/*

-МАН сонгуульд ялснаас хойш 100 хоног өнгөрсөн. Энэ хугацаанд тэд юу хийв, улс орныг хааш нь чиглүүлж явна, иргэд юу хүлээж байсныг нэгтгэн тайлан гаргасан. МАН-ын дарга М.Энхболд зөвхөн ах дүү, амраг садныхаа 20 гаруй хүнийг томилсон нь улс төрийн хүчин мөн үү гэдэгт эргэлзэхээр байдал үүсгэлээ. Эсвэл нэг хүн дарангуйлал тогтоох гэж ах дүү амраг саднаараа мопияц байгуулж байгаа юм уу. Мопияц бол зөвхөн гэр бүл дээр тогтдог. Мөн МАН-аас томилогдсон удирдах албан тушаалтнуудын жагсаалтыг гаргасан. Нэр бүхий гишүүд дарга нарын ойр дотны хүмүүсээс гадна Монголын морин спорт уяачдын холбоо холбоогоороо дарга болсон. Холбооны дэд тэргүүн нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, дэд ерөнхийлөгч нь Барилга хот байгуулалтын яамны дэд сайд болсон. Нийслэлийн морин спорт уяачдын холбооны дарга, тэргүүлэгч нь ХХААХҮ-ийн яамны газрын дарга нар болцгоосон байна. Энэ юуг харуулж байна гэвэл өнгөрсөн хугацаанд хийсэн бүх томилгоо ах дүү амраг садны сүлжээгээр буюу өндөр албан тушаалд томилсон томилгооны 70 хувь нь МАН-ын удирдах албан тушаалтай ямар нэг байдлаар холбогдож байна. Иймл төр 100 хоногийн хугацаанд бүрдэж бий болсон байна. Монголыг ирэх дөрвөн жил удирдах баг тэр чигтээ МАН-ын удирдах албан тушаалтнуудын ах дүү, амраг садан гэр бүлийн баг байх юм гэдгийг 100 хоногийн хугацаанд харлаа. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг судлаад үзэхэд бодитой шийдвэр гаргасангүй. Ядаж 100 хоногийн дотор зөв чигээ олох ёстой. Нийгэмд хамгийн их тулгамдсан асуудал бол авлигатай тэмцэх. Авлига албан тушаалын гэмт хэрэг бүх шатандаа эх захаа алдсан учраас 100 хоногийн хугацаанд МАН авлигтай тэмцэхээ хэрхэн эхлэхийг ард түмэн хүлээж байсан. Харамсалтай нь юу ч хийсэнгүй. Эдийн засаг хямарлаа гэсэн асуудлыг МАН сонгуулийн өмнөх нэг жилд хангалттай ярьсан. Тиймээс Монгол Улсыг хямралаас гаргах төлөвлөгөөгөө МАН танилцуулсангүй. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хямралаас гаргах төлөвлөгөө баталж чадалгүй гурван сарыг ардаа орхилоо. Өндөр настан, залуучуудтай холбоотой нэлээд олон ажлыг гацаалаа. Засгийн газрын хуралдаан болгон дээр 2-3 ажлыг МАН-ын Засгийн газар зогсоосон гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Ажил хийдэг биш зогсоодог Засгийн газар байгуулагдсан гэж дүгнэхэд буруудахгүй.

## С.Чинзориг: Ээжүүд даатгалд хамрагдсан хэлбэрээс үл хамаарч цалингаасаа 100 хувь тэтгэмж авдаг болно

*/УИХ-ын гишүүн/*

-МАН 2016 оны УИХ-ын сонгуульд олон хүүхэд төрүүлж өсгөсөн ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах, малчдыг нийгмийн даатгалд хамрагдуулж ирээдүйн баталгааг дээшлүүлэх зорилгоор олон зорилт дэвшүүлсэн. Энэ зорилтын хүрээнд малчид болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хууль эрхзүйн орчин бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна. Хэрэгжүүлэхийн тулд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хуулийн төсөл боловсруулаад өнгөрсөн долоо хоногт УИХ-ын даргад өргөн барилаа. Яагаад ийм хуулийн төсөл өргөн барив гэхээр улсын хэмжээнд 1.1 сая ажил хөдөлмөр эрхэлдэг хүн бий. Тэдний 330 мянга орчим нь малчин. Цаана нь 150 мянга орчим хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна. Энэ бол нийт ажил эрхэлж буй хүмүүсийн 47 хувь байгаа юм. Тэгсэн атлаа нийгмийн даатгал шимтгэл төлөлт маш бага. Нийт малчдын аравхан хувь нь нийгмийн даатгалын шимтгэлээ төлж байгаа. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 15 орчим хувь нь шимтгэлээ төлж байна. Ингээд бодоод үзэхээр малчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн баталгаа алдагдах хүнд байдалтай байгаа. Иймд олон жил малаа дагасан, хувиараа хөдөлмөр эрхлэхдээ нийгмийн даатгалын шимтгэл төлж чадаагүй иргэдэд зориулж, хууль эрхзүйн орчны зохицуулалт хийхээр болсон. Тэд төлөөгүй байгаа нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж болно. Ингэснээр хэд хэдэн давуу талтай болно. Малчин болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс нийгмийн даатгалын шимтгэл төлөгч болсноор ирээдүйн баталгаа сайжирна. Өндөр настай болсон хүмүүс нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүснэ. Түүнчлэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл оруулсан. Уг хуулиар бид таван багц асуудал шийднэ. Нэгдүгээрт, хүүхэд төрүүлсэн ээжүүд жирэмсний болоод амаржсаны тэтгэмж авдаг. Ингэхдээ даатгалд хамрагдсанаасаа шалтгаалж ялгамжтай тэтгэмж авч байна. Даатгалд хамрагдсан ээжүүд цалингийнхаа 100 хувь, сайн дураар хамрагдсан бол 75 хувийн тэтгэмж авдаг. Тиймээс тэтгэмж авахдаа даатгалд хамрагдсан хэлбэрээс үл хамаарч цалин хөлснөөсөө 100 хувь тэтгэмж авдаг болохоор хуульчилж өгөх юм. Мөн ээжүүд хүүхэд төрүүлээд гурван нас хүртэл нь гэртээ асран өсгөдөг. Энэ хугацааны наймхан сард нийгмийн даатгал нь төлөгдөж явдаг. Бусад хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөгддөггүй. Ингэснээр хүүхэд төрүүлсэн эмэгтэй орлогогүй болж, ажилласан жил, шимтгэл төлсөн жил нь тасардаг. Ирээдүйд тэтгэвэрт гарахад нь ажилласан жил нь цөөн болж бага тэтгэвэр тогтоолгож байгаа. Тиймээс хүүхдээ гурван нас хүртэл нь өөрөө асарсан бол тэр хугацааны ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг таслахгүй байхаар хуульчилъя. Ажил хийж байсан буюу шимтгэлээ төлж байсан ээж гурван жил хүүхдээ харах бол өмнө нь өөрийнх нь төлсөн тэтгэмжийн сангаас буцаан төлдөг болно. Нэг ёсондоо гэртээ байх гурван жилийн хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг өмнө нь өөрийнх нь төлж хуримтлуулсан мөнгөнөөс төлнө.

> ...Малчин болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс нийгмийн даатгалын шимтгэл төлөгч болсноор ирээдүйн баталгаа сайжирна. Өндөр настай болсон хүмүүс нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүснэ. Түүнчлэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл оруулсан...

Дугаарын **60** мөр

## Өвдөхөөсөө өмнө өөрийгөө хайрлаач

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Иргэд энэ үзлээсээ салж чадахгүй байгаа нь ч учиртай. Манай улсын иргэдэд эрүүл мэндийн талаархи зөв ойлголт, мэдлэг мэдээлэл, боловсрол алга. Жилд нэг удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна. Тэгэхдээ ихэвчлэн өндөр настан, төрийн албан хаагч, ерөнхий боловсролын сурагчид урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг. Хувиараа бизнес эрхлэгчид, оюутан, хувийн компанийн ажилчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдана гэвэл үлгэрийн далай болно биз. Ядахад дарин дээр давс гэгчээр ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгаас эрүүл мэндийн хичээлийг хүртэл хасчихав. Ингээд хэлчихвэл улстай л холбоотой байна гэж бодож магадгүй. Монгол Улсын Үндсэн хуульд эрүүл мэндээ хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэж заасан байдаг. Гэтэл бид өөрсдийнхөө эрүүл мэндийн төлөө өдөр бүр анхаарал хандуулдаг уу. Ядаж л эмийн сангаас эм авахаасаа өмнө өрхийнхөө эмчид үзүүлдэг үү, сардаа биш гэхэд жилд нэг удаа эмнэлэгт ханддаг уу гэдэг нь асуудалтай. Энэ байдал өнөөгийн нийгэмд нийтлэг болсон. Эмнэлэгт үзүүлэхгүй явж байгаад нэг удаа үзүүлэхэд "...өвчний эцсийн шат болсон байна, өвчин чинь хүндэрч, эрт үзүүлэхгүй яасан юм" гэдэг эмчийн хатуухан үгтэй тулгардаг. Ингээд л ниргэсэн хойно нь хашгирав гэдэг үлгэр эхэлж, хэн нэгнээс тусламж гуйж, хандивын тоглолт хийлгэнэ. Ер нь ингэх шаардлага байна уу. Эмнэлгийн эм тариа, ор хүрэлцдэггүй XX зуун ард хоцорч, иргэд нь өөрсдийн эрүүл мэндийн төлөө санаа тавьдаг, өөрийнхөө төлөө гүйдэг XXI зуун өрнөж байна. Тиймээс өөрийнхөө төлөө өөрөө гүй. Захын эмнэлэгт дархлаажуулалтын вакциныг таваг хоол авч идэх мөнгөөр л хийдэг болчихож. Иргэний сайн дураар хийлгэх вакцины жагсаалт хүртэл гарсан байна билээ. Тухайлбал, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Сэргийлэх Тарилгын Кабинетад сайн дурын дархлаажуулалт хийлгэх боломжтой. Тус эмнэлэгт, Сахуу татрангийн хоргүй сүү нэг тунг нь 3000, В вирүст хепатитын эсрэг вакцин 5000, Томуугийн болон Улаанбурхан /улаанбурхан-гахайн хавдар-улаануud/ вакцин 10000, А вирүст хепатитын эсрэг вакцин 28110 төгрөгийн үнэтэй хийж байх жишээтэй. Өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалаад ганцхан вакцин хийлгэхэд дааж давшгүй мөнгө хэрэггүй нь. 3-28 мянган төгрөг байхад л хангалттай. Хэрвээ хүсэх л юм бол аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх боломж манай улсад бүрэн байна. Харин бид хэнэггүй зангаа хаях л үлдэж. Улсын эмнэлгийн үйлчилгээ муу байдаг цаг аль хэдийнэ ард хоцорч. Тиймээс үндсэн хуульд заасан журамт үүргээ биелүүлэн сард нэг удаа ч болов эмнэлэгт хандаж, ядаж л 5000 төгрөгөөр нэг вакцин хийлгэчихэж бай. Өвчнөө эцсийн шатанд нь хүргэж хэн нэгнээс эмчилгээний зардал гуйж хэвтэхийн оронд эрүүл мэндээ хамгаалах, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлбэл дээргүй юу. Одоо үед чинь өвчин хийсч биш хэлж ирдэг болсон гэдгийг дэлхий нийтээр баталж, эрүүл мэндийнхээ төлөө санаа тавьдаг болсон байна. Монголчууд мода хөөх дуртай хүмүүс дээ. XXI зууны эрүүл мэндийн модыг ч орхигдуулалгүй хөөе л дөө, бүгдээрээ.

ХҮМҮҮС

# Г.ЛХААХҮҮ: БОЛОВСРОЛЫН САЛБАРТ АМЬДРАЛЫН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Дөрвөн настай байхад аав надаар чулуу хормойлуулж, маани өргүүлдэг байв. Тэр өрсөн маани дээрээ 60 гаруй жилийн дараа очиж, сэргээснээс хойш жил бүр очиж, хүндэлж, биширч явдаг болсон. Зураг хөрөг нь ч манайд хадгалагдаж байдаг. Аав маань намайг бага байхад тэнгэрийн оронд морилсон доо. Харин ээж минь 86 нас зооглосон. Манайх өнөр өтгөн айл. Би эхээс наймуулаа. Дээрээ долоон ахтай айлын ганц охин. Тийм болохоор ч тэр юм уу эцэг эх минь надад ном эрдмээ өвлүүлсэн байдаг юм. Аав ээждээ туслан хөдөө байж байгаад найман настайдаасургуульдорсноосоо хойш төв газарт амьдарч байна. Миний ажлын гараа Баянхонгор аймгийн Галуут сумын Сүмбэрийн бааз нэртэй бригадын бага сургуулиас эхэлсэн түүхтэй. 16-хан настай хоёр салаа гэзэгтэй охин бага ангийн багш хийж эхэлснээс хойш эдүгээг хүртэл 60 гаруй жилийг ардаа орхижээ.

**-Та 16 насандаа багш болсон байх нь ээ?**

-Тэр үед долдугаар ангиа төгсөөд техникумд явдаг байлаа. Би багшийн сургуульд нэг жил суралцсан юм. Тэр үеэс багшилж эхэлсэн. Хожим Архангай аймгийн багшийн сургуульд суралцан бага ангийн багшийн мэргэжил эзэмшиж байв. Түүнээс хойш 10 гаруй жил багшилсныхаа дараа хоёр салаа гэзэгтэй охин бус хөдөөгийн сургуульд 20 орчим жил ажилласан туршлагатай, зургаан хүүхэдтэй алдарт эх, өнөр гэр бүлийн эзэгтэй болсон хүн мэргэжлээ ахиулж, хөгжих сэтгэл өвөртлөн Улсын Багшийн Дээд сургуулийн монгол хэл, уран зохиолын багшийн ангид элсэж билээ. Ангийн оюутнууд бүгд л ЕБС-иа төгссөн залуус. Ажиллаж байгаад элссэн хүн тун цөөн. Тэд насаар дүү хүмүүс байлаа. Сургуулиа онц дүнтэй дүүргэсэн тул Гэгээрлийн яамнаас Багшийн сургуульд багшаар томилж энэ үеэс тус сургуультайгаа хувь заяагаа холбосон юм. Түүнээс хойш сургуульдаа 30 гаруй жил багшилсан байна.

**-Ажлын анхны гараа тань Соёлын довтолгоон ид өрнөж байсан тэр үед эхэлжээ. Багш учраас нэлээд үүрэгтэй оролцож байсан болов уу?**

-Тэгэлгүй яах вэ. 1958, 1959 онд Соёлын довтолгоон ид өрнөж байлаа. Тэр ажилд багш нар дайчлагдана. Залуу ч байж. Зуны амралт болмогц бригадаас морь авчирч өгнө. Тэр үед сүүн тасаг гэж байв. Нөгөө морио өглөө унаж давхиад сүүн тасагт хүрч, саальчин бүсгүйчүүдэд бичиг үсэг заана. Багшлах боломжтой бол шууд л багшлуулдаг байсан. Өглөө мориор очиж хичээлээ заачхаад гэр рүүгээ буцдаг байв. Зуны улирал учраас айлууд голын дагуу зусландаа бууж, миний явдаг замаар дүүрэн айлууд буучихсан байдаг тул би нохойноос айгаад нилээд холуур тойрч явдаг байж билээ. Соёлын довтолгооны ажилд оролцож, соёлын үр тарилцаж явсан. Тэр үе одоотой адилхан байсангүй. Айлуудад орж, авдарыг нь онгойлгуулж, орны даавуу байгаа эсэх, хүний тоогоор нүүр, гарын алчууртай эсэхийг нь шалгадаг байлаа. Хүн бүрт алчуур байхгүй. Хүн бүрийг өөрийн гэсэн алчууртай, амаа угаах сойзтой болгохоос эхлээд бүх нийтээр бичиг үсэгтэн болгох их үйлст ёстой л унтах нойроо хасаж, гар бие оролцож явсан даа. Дараа нь аймгийн төвд суурьшиж, хань, үр хүүхэдтэй болсон. 1960-аад онд аймгийн МХЗЭ-ийн Бүгд хурлын гишүүнээр сонгогдов. Үүрэг хариуцлага ч нэмэгдэв. ХЗЭ-ийн хорооны ажилчин үйлчлэгч нарыг бичиг үсэг тайлах ажилд бас л томилогдсон. Т и й м э э с орой хичээл тарсны дараа хүмүүсдээ бичиг үсэг заадаг байлаа. Хөгжилтэй зүйл их болно. 35 үсгийг нь дэвтэр дээр нь бичиж өгөөд явуулна. Надаас хэдэн насаар ахмад хүмүүс маргааш нь гэрийн даалгавраа шалгуулахдаа нэг амьсгаагаар том “а” бага “а” гээд л үргэлжлүүлээд уншчихна. Залуу байсан болохоор тэр үү, инээдээ барьж дийлэхгүй. Шавь нарынхаа өмнө тачигнатал инээчихдэг байлаа. Тэгээд “Уучлаарай. Та нарыг шоолоогүй шүү. Хүүхдээс өөр байхаар чинь багш нь та нараар бахархаж инээсэн юм” гээд л тайлбарладаг байв. Соёлын довтолгооны ажилд багш нар их үүрэг гүйцэтгэсэн. Эцэг эхийн хороонд очиж, сонин хэвлэл уншиж өгнө, төр засгийн хийж хэрэгжүүлж буй ажлыг таниулна. Ийм л үйл ажиллагааг явуулж байлаа. Соёлын довтолгооны үр шимээр маш олон монголчууд бичиг үсэг тайлагдсан. Бүр 1960, 1970-аад оны үед бүх нийтээрээ бичиг үсэг тайлагдсан Азийн анхны орон болж, ЮНЕСКО-д бүртгэгдсэн удаатай.

**-Анхны юм бүхэн дурсгалтай байдаг. Таны анхны хичээл ямар байв. Тэр үеэ эргэн дурсвал?**

-Багшийн сургуульд нэг жил суралцсаныхаа дараа нутагтаа очихдоо Боловсролын хэлтэст сурлагын дэвтрээ бариад очиж байлаа. Харин Боловсролын хэлтсийн дарга “Чамайг сурч байсан газарт чинь хуваарилчихвал хүүхдүүдтэй найзлаад ажлаа хийхгүй байх. Хаана хуваарилдаг билээ” гэж байгаад аймгийн төвөөс 12 км-ын зайтай бригадын сургуулийн багшаар хуваариллаа. Захирал нь ямар хүн бэ гээд асуутал “Д.Тампуулин” гэж байна. Миний бага ангийн багш байсан учраас би ч дуртай нь аргагүй зөвшөөрсөн. Багын л багш мэргэжилд хайртай байж билээ. Ингээд багш дээрээ томилолтоо бариад очтол, “Конспект гэж мэдэх үү” гэж асуув. “Үгүй” гээд үнэнээ хэлтэл нэг ном өгөөд “Энэ номыг уншаад хүүхдэд яаж өөрийн арга барилаар заахаа бич” гэв. Би ч өөрийнхөөрөө бичээд хичээлээ заасан. Анхны хичээл биеэ барьж, сандарсандаа чичирч байгаа мэт эвгүй байж билээ. Тэр үеийн хүүхдүүдийн дунд насаар надтай чацуу хүүхдүүд ч байсан. Хичээлээ заахаар ормогц дээл өмссөн ханхайсан залуус сууж байгааг хараад сандраад хөлс гарчихсан. Харин сүүлдээ тайвширч, хоёр дахь өдрөөсөө сандрахаа больчихсон. Өөрөө дурлаж сонгосон юм хойно сайхан байлгүй яах вэ. Намайг багшлаад гурван долоо хоног болж байтал аймгийн Боловсролын хэлтсээс шалгалт ирж билээ. Тэр үед Боловсролын хэлтсийн сурганы кабинетын дарга байсан Даваасүрэн гуай миний хичээлд суулаа. Намайг, шавь нарыг маань шалгахаар ирсэн талаар огт бодолгүй энэ хүн яагаад орж ирсэн юм бол гэж дотроо бодож байв. Тэгээд тоосон шинжгүй хичээл орж байсан гэрийнхээ баганыг түшиж зогсчихоод л хичээлээ заасаар нэг мэдэхэд бүтэн цаг өнгөрсөн байсан. Залуу байсан учраас зоригтой байсан юм болов уу. Дараа нь миний хичээлийн талаар ярьж, “Чи Багшийн сургуульд нэг жил суралцсан болохоор багшлах ирээдүй байна” гэж хэлсэн. Тэгээд багш хүн биеэ зөв авч явах ёстой гэх мэт амьдралын нарийн зүйлсийг захисан. Түүнээс хойш өдөр өдрөөр суралцсаар гайгүй сайн багш болж чадсан гэж боддог.

**-Та ер нь сурлагаар гайгүй хүүхэд байжээ дээ?**

-Гайгүй сурагч байсан юм байлгүй. Шинэ жил болох гэж байхад, хоёрдугаар ангийн улирлын дүн гарч, эцэг эхийн хурал болов. Багш маань надад нэг метр гаруй цагаан даавуу, хэдэн ширхэг цохио чихрийг “Онц сурсан учраас шагнал” гэж хэлээд өгсөн юм. Тэр үед “Чи хойд ширээнийхээ хүүхэдтэй их ярьдаг шүү. Хичээл дээр ярьж болохгүй. Хэрэв яриад байвал онц сурч чадахгүй” гэж



захиж байсан. Үүнээс хойш хичээл дээр ярихаа больсон. Гэхдээ багшийнхаа талаарх дурсамжийг 2014 онд гаргасан номдоо оруулсан юм. Багшийн мэргэжил сайхан. Хүмүүс залхаж байна гэж хэлдэг. Би хэзээ ч залхаж байгаагүй. Одоо ч, МУБИС-ийн Багшийн сургуульдаа зөвлөх багшаар ажиллаж, номоо бүтээлээ туурвисаар л байна. Бага ангийн хүүхдийг сургах үйлд 16 наснаасаа өнөөдрийг хүртэл хувь заяагаар холбоотой явна даа.

**-"Цагаан толгойн" Г.Лхаахүү гэж таныг тодотгодог. Таны бичсэн номыг үзэж, маш олон хүн бичиг үсэг тайлагдсан. "Цагаан толгой"-той холбогдсон түүхээсээ сонирхуулаач?**

-Бага ангийн багшаар 16 жил ажиллахдаа математик, монгол хэлний хичээлээр тайлбартай дасгалын аргыг хүүхдүүддээ эзэмшүүлдэг, сурагчдынхаа яриаг хөгжүүлдэг багш гэж үнэлэгдэн МУБИС-д монгол хэл уран зохиолын багш мэргэжлээр суралцахаар оюутан болж дөрвөн жил сурч, сургуулиа дүүргэв. Сургуулиа онц төгссөн тул Боловсролын яам Багшийн сургуульд багшаар томилоо. Сургуулиа төгсөөд хэдэн жил ажиллаж байтал нэг өдөр гавьяат багш Б.Цэвэгжав гуай намайг сурагласаар сургууль дээр ирж билээ. "Ном бичиж

Монголынхоо тал хувийг бичиг үсэгтэй болгоход өөрийн хувь нэмрээ оруулсан минь энэ насны хамгийн том буян байх. Амьдралын зөв замыг нээж өгсөн эцэг эх, багш нартаа баярлаж явдаг. Гавьяаныхаа амралтад суусанаасаа хойш ч сурах бичиг зохиоход шавь нарынхаа хамт ажиллаж байна. Өөрийн амьдралын туршлага, бусад эрдэмтдийн хийсэн бүтээл, гадны туршлагатай уялдуулж бичсэн учраас зурган настнуудын сурах бичгийг нэлээд чансаатай болсон гэж боддог.

**-6, 7, болон 8 насны "цагаан толгой"-г бүтээсэн хүн таниас өөр байдаггүй байх?**

-Бага дунд сургуулийн багш нар, хүрээлэнгийн эрдэмтэд сурах бичиг бүтээн хэвлүүлж байсан. Гэхдээ гурван насны сурах бичгийг бичсэн хүн Монголд надаас өөр байхгүй. Б.Цэвэгжав багш 1946 оноос хойш цагаан толгой бичиж байсан. Харин би 1982 оноос хамтарч сурах бичиг бичсэн юм. Тиймээс миний залгамжилсан өв бол яах аргагүй Б.Цэвэгжав багшийн "Цагаан толгой" юм.

**-Боловсролын салбарт хэдэн жил ажиллаж байна вэ?**

-Боловсролын салбартаа өнөөг хүртэл 60 шахам жил ажиллаж байна.

**-Багшилж байх хугацаанд тохиолдсон, одоо ч**

**вэ?**

-Багш хүн хүүхдийн сэтгэхүйд үр тарьж түүнийгээ ургуулдаг цэцэрлэгч. Хүнийг хөгжүүлдэг, сайхан сэтгэлийг бий болгодог. Ялангуяа бага ангийн багш. Цав цагаан цаас шиг цэврэхэн сэтгэхүйтэй хүүхдийн оюун ухааныг нь хөгжүүлж байна гэж бодох хамгийн сайхан мэдрэмж байдаг. Хүнд тус хүргэж, хүнийг мэдлэгтэй болоход нь тусалж,нөлөөлж,үлгэрлэжбуй нь багш мэргэжлийн хамгийн сайхан чанар байх. Амьдрал дээр бол хаана ч очсон багш хүн аяга цай олоод уучихдаг юм билээ. Багш ирлээ гээд хоол хүртэл бариад ирдэг юм. Нэг талаар хүний амьдралд, нөгөөтэйгүүр, нийгэмдээ

Үсэг уншуулж, цээжээр нэг үг бичүүлж сургахын оронд анхаарлыг нь төвлөрүүлж, шилжүүлж сургах, сэтгэн бодох, харьцуулах чадварыг нь хөгжүүлээсэй гэдэг талаас нь бичсэн юм. Багш өөрөө жигд ажиллаж чадвал муу сурлагатай хүүхэд бараг гарахгүй. Шавийн эрдэм багшаас гэдэг. Угтаа тухайн хүүхдийн оюун ухааныг танин мэдэж ажиллах хэрэгтэй юм.

**-"Оюуны мэлмий нээх гэгээн судар" гэх шинэхэн номын тань нээлт өнөөдөр болно. Номоо бүтээхэд хэдий хэрийн хугацаа зарцуулав?**

-1982 оноос хойшхи "Цагаан толгой", Монгол хэлний сурах бичиг дээр ажилласан

...Муу сурагч гэж байдаггүй. Харин сайн ажиллах шаардлагатай сурагч байдаг. Хүн бүрийн оюун ухааны шинэ зүйлийг хүлээж авах, тогтоох чадвар нь харилцан адилгүй байх нь бий. Тухайн багшийн урд 26 сурагч сууж байна гэж төсөөлбөл, тэнд 26 өөр ертөнц байгаа. Тэр ертөнцийг танин мэдэж, хүүхдийг "муу" гэх нэрээс салгах нь багшийн үүрэг, хариуцлага. Сул сурлагатай хүүхдийн оюун ухааных нь хөгжил бусдаасаа хоцорчихсон байдаг...

боловсруулдаг. Тэр бүрийг нэгтгэн номоо гаргалаа.

**-Бидний яриа мэргэжлийн чиглэлээр илүүтэй өрнөлөө. Одоо таны хувийн амьдралыг сонирхмоор байна. Та одоо хэдэн ач, зээтэй болж байна вэ?**

-17 ач, зээ, найман гучтай. Ач, зээ, гучаа харахаар сэтгэл баясаж хүний ертөнц их өөрчлөгддөг юм байна. Тэднийгээ хэрхэн танин мэдүүлэх, зөв хүмүүжүүлэх вэ, яаж сайн хүн болгох гэсэн сэтгэл өөрийн эрхгүй л төрдөг юм билээ. Тэгээд л тэдэндээ зориулж шүлэг хүртэл тэрлэсэн шүү.

**-Таныг шүлгээс гадна урын сандаа дуутай гэж сонссон?**

-Дуу бий бий. Ер нь хүнд аав ээж, төрсөн нутаг юу юунаас илүү эрч хүч өгдөг юм билээ. Аавынхаа маани өрсөн уулан дээр нь 2008 онд очиж, чулуун нь сэргээсэн юм. Тухайн үед нутаг орноо харж, өөрийн бага насны дурсамжаа санагалзан зогсч байтал аав, ээжийн тухай шүлгийн санаа төрсөн. Шүлгээ тэр ондоо бичээд хадгалчихав. Гэтэл нэг удаа шүлгээ дуу болгоё гэсэн бодол төрөх нь тэр. Тэгээд л дуу болгосон. 2014 онд урлагийн гавьяат зүтгэлтэн Б.Бямбабаяраар ая хийлгэснээр "Ээж аав минь" гэх дуу минь бүтсэн түүхтэй. Түүнчлэн, нутгийнхаа ойд очих үедээ "Нутагтаа ирлээ" дууныхаа шүлгийг бичиж, аяыг нь мөн л Б.Бямбабаяр

**-Мэргэжлийн чиглэлээр бичсэн ном, сурах бичгийн тоо хэд болж байна?**

-Мэргэжлийн чиглэлээр 50 гаруй сурах бичиг, өгүүлэл бий.

**-Хүүхдүүдээс тань таны мэргэжлийн өвлөсөн хүн бий юу?**

-Байгаа байгаа. Зурган хүүхдийн маань дөрөв нь миний мэргэжлийг өвлөж авсан, хоёр хүүхэд маань докторын зэрэг хамгаалсан хүмүүс бий, хоёр нь эдийн засагч, эмч мэргэжилтэй. Хамгийн том нь эдийн засагч.

**-Ач, зээ нар тань өөрийн тань бичсэн "Цагаан толгой"-гоор бичиг үсэг тайлагдаж байна. Таниар бахархдаг байх?**

-Хамгийн бага хүүхэд маань миний бичсэн "цагаан толгой"-г үзэж байсан юм. Ач нар ч гэсэн мөн адил. Тэд миний эмээгийн "цагаан толгой" гээд ихэд хүндэлж, хайрладаг юм билээ.

**-Гэр бүлийнхээ хүнийг танилцуулаач?**

-Манай нөхөр худалдааны гавьяат ажилтан н.Бэгз гэж хүн бий. Олон жил улс, нийгэмд төрийн ажил хийж явсан. Бид хоёулаа өндөр насны тэтгэвэрээ суусан.

**-Ажлын өрөөний хананд тань маш олон медалиуд байна. Ямар ямар шагнал урамшуулал хүртэж байсан бэ?**

-Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон,

# ХАА 60 ГАРУЙ ЖИЛИЙГ ЗОРИУЛЖ ЯВНА



чадах уу" гэж асуув. Хэдийгээр чадах эсэхдээ эргэлзэж байсан ч Б.Цэвэгжав багшийнхаа удирдлага дор анхныхаа "Цагаан толгой"-н номыг 1982 онд бичиж боловсруулан хэвлэлтэд өгсөн. Тэндээс миний амьдралын нэг их сургууль эхэлсэн гэж боддог. Үндсэндээ 1982-1994 онд Б.Цэвэгжав багштайгаа, 1994-2005 он хүртэл шавь нартайгаа , 2008-2014 он хүртэл бусад багш нар шавь нартайгаа хамтран "Цагаан толгой" сурах бичгийн номоо бичсэн. Номоо таниулахын тулд бага ангийн багш нарт арга зүйг нь ойлгуулахаар 18 аймгаар явж, семинар зөвлөгөө өгч, лекц уншдаг байлаа. Тухайн үед "Хуучин иймбайсан, үүнийг ингэж уламжилж авна, хуучныгаа шинэтэйгээ ингэж холбоно. Чи өөрийнхөө бодол санааг номтойгоо холбосноор чиний бодол санаа, хуучин арга барил, шинэчлэлийг хооронд нь сүлэлдүүлж, яг хярам шиг болгож байж хичээлийг заагаарай" гэж зөвлөдөг байлаа. Сүү ус хоёр салдаггүйтэй адил багш хүн хуучин, шинийг сүлэлдүүлж, өөрийн ухаантайгаа нийлүүлэн сая нэг амттай хярам шиг болгосны эцэст хичээлээ заах ёстой гэж зөвлөдөг юм. Очоогүй аймаг байхгүй. Ингэж явтал нэг мэдэхнээ "Цагаан толгой"-н Лхаахүү багш гэдэг нэр авчихсан байсан. Эхэндээ багшийнхаа заавраар номоо бүтээдэг байсан бол сүүлдээ өөрөө шавь нараа удирдан долоон настай хүүхдийн сурах бичгийг бичиж, Боловсролын яамны тендерт нэгдүгээр байрт шалгарч байлаа. Дараа нь зургаан настнуудын сурах бичгийн тендерт орж мөн нэгдүгээр байр эзэлсэн. Ийнхүү улс даяар дагаж мөрдөгдөх сурах бичиг болсон юм. Сүүлийн номыг "Монгол хэл" гэж нэрлэж байгаа. Гэхдээ "Цагаан толгой" гэсэн үг л дээ. 30-аад жилийн турш "Цагаан толгой"-той холбогдож яваа болохоор багш нар ингээд нэрлэчихсэн юм билээ. Аавынхаа нэрийн хажуугаар хийсэн бүтээлээрээ нэрлэгдсэндээ баярлаж явдаг даа.

**-Таны зохиосон "Цагаан толгой" номыг ашиглан бичиг үсэг тайлагдсан хүний тоо хэд хүрч яваа бол?**

-Нэг сая 600 мянган хүүхэд миний бичсэн номыг ашиглан бичиг үсэг тайлагдсан гэсэн статистик тооцоо байдаг.

**тодхон санагддаг дурсамж байдаг байх. Бидэнд сонирхуулбал?**

-Багш, шавь хоёр их ойр харилцаатай байх ёстой болов уу. Хичээлийн үеэр болсон сонин дурсамж бий. Нэг удаа даддага удирдахдаа хүүхдийн өмнө гармагцаа нэг ч үг дуугарч чадахгүй зогсчихдог оюутантай таарч билээ. Анхны хичээл заахынх нь өмнө хамтдаа сайтар бэлдээд хичээлдээ ортол, юу ч дуугарч чадахгүй зогсчихдог байгаа. Би ч хүүхдүүдэд мэдэгдэхгүйн тулд "Багшийнх нь бие өвдсөн байна" гэж хэлээд өөрөө хичээлийг нь үргэлжлүүлж байсан удаа бий. Дараа нь дуудаж авчраад өөртөө хичээл заалгаж, ангийнхаа хүүхдүүдэд хичээл заалгасаар "нүүрийг нь хагалж" байж билээ. Нүүр хагарна гэж байдаг юм. Одоо тэр оюутан тун сайн багш болсон.

**-Таны мэргэжлийн хамгийн сайхан зүйл нь юу**

тустай мэргэжил.

**-Цав цагаан цаас шиг хүүхдийн сэтгэхүйд анхны зургийг нь зурах хүн бага ангийн багш гэж та хэллээ. Ер нь муу сурагч гэж байдаг уу. Мэргэжлийн хүний хувьд?**

-Муу сурагч гэж байдаггүй. Харин сайн ажиллах шаардлагатай сурагч байдаг. Хүн бүрийн оюун ухааны шинэ зүйлийг хүлээж авах, тогтоох чадвар нь харилцан адилгүй байх нь бий. Тухайн багшийн урд 26 сурагч сууж байна гэж төсөөлбөл, тэнд 26 өөр ертөнц байгаа. Тэр ертөнцийг танин мэдэж, хүүхдийг "муу" гэх нэрээс салгах нь багшийн үүрэг, хариуцлага. Сул сурлагатай хүүхдийн оюун ухааных нь хөгжил бусдаасаа хоцорчихсон байдаг. Түүнийг нь нээж, хөгжүүлэх үйл ажиллагаа багш хүн хийх ёстой. Тийм ч учраас шинэ номоо хүүхдийг хөгжүүлэх тал дээр нь анхаараасай.

30 гаруй жилийн хугацаанд бүтсэн ном гэж ойлгож болно. Өнөөдрийг хүртэл найман настны, дараагийнх нь долоон настай хүүхдийн, зургаан настны, малчин хүүхдийн, бичиг үсгийн боловсролгүй хүүхэд, албан бус боловсролын гэх мэт олон төрлийн цагаан толгойг бүтээхэд гар бие оролцсон байна. Энэ бүгдийгээ нэгтгээд, алдаа дутагдлаа засч, өмнөх ололтоо бататган хойч үедээ сурах бичиг хийхэд гарах алдаа, амжилтын талаар бичиж үлдээе гэсэн сэтгэлээр сурах бичгээ бүтээлээ. Миний 30 жилийн бүтээл гэхэд хилсдэхгүй. "Цагаан толгой" сурах бичгийг зохиоход онолын тун өвөрмөц төвшин шаарддаг юм. Нэгдүгээр ангийн сурах бичиг хэдэн үсэг бичээд болчихно гэж зарим хүмүүс ойлгодог. Гэтэл үгүй. Тэнд хүнийг хүн болгох, хүүхдээ хөгжүүлэх, эрдэм номд шамдуулах гэх мэт зүйлийг цогцоор нь бодож

зохиож, МУГЖ С.Ганзориг дуулсан юм. Хоёр сайхан дуу бий. Тун удахгүй "Монгол бүсгүй" гэх шүлэг минь дуу болох байх.

**-Урын сандаа хэчнээн шүлэгтэй вэ. Ер нь ном гаргая гэж бодож байсан уу?**

-30-аад шүлэг бий. Шүлэг бүрт санаа хэрхэн төрснийг тэмдэглэсэн тайлбартай. Шүлгийн ном гаргая гэсэн бодол бий. Одоо сурах бичиг дээр ажиллахгүй байгаа учир чөлөөт уран бүтээлдээ анхаарч байгаа.

**-Цагаан толгой дээр таны бичсэн шүлэг бий юу?**

-1996 оны "Цагаан толгой" дээр ихэвчлэн таавар шүлэг бичиж хэвлүүлсэн. Тухайлбал, "Авдар гэсэн үгэнд А үсэг шамдан оролцов. Адил тэнцүү эрхтэй шүү гэж анхны а өндөлзөв" гээд эхэлдэг. Энэ мэтээр сурах бичиг бий. Тэр бүрийг оролцуулаад ном гаргая гэж бодож байгаа.

Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас одонг тус тус хүртэж явсан. Олон нийтийн байгууллагаас аваагүй шагнал гэж бараг байхгүй. Саяхан гэхэд Оюунлаг эрдэмтэн эмэгтэйчүүдийн холбооноос "Алтан од" шагналыг авсан. Хэдэн жилийн өмнө шавь нар маань надад "Ард түмний гавьяат" гэсэн цол өгч билээ. Их гоё үгтэй. "Ард түмний санал асуулгаар энэ шагналыг танд гардуулж байна. Энэ бол таны хөдөлмөрийг үнэлж буй хэрэг бөгөөд ард түмний дээд шагнал юм" гэсэн бичигтэй. Шавь нар маань өгсөн учир их хүндэтгэлтэй хадгалдаг.

*Багшийн хүний ажлын бодит дүр төрхийг тодорхой өгүүлсэн оюунлаг, сэтгэл хүрсэн сайхан ярилцлага өгсөн танд баярлалаа. Цаашдын амьдрал тань аз жаргал, уран бүтээлд тань дундрашгүй эрч хүч цогцолж байхын ерөөлийг дэвшүүлье.*

ДЭЛХИЙ



## Ким Жон Уны төрсөн өдрийг улс даяар тэмдэглэнэ

Хойд Солонгос улсын ард иргэд ирэх жилийн нэгдүгээр сард залуу удирдагч Ким Жон Уны төрсөн өдрийг албан ёсоор улсын баяр болгон өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлэхээр болжээ. Хойд Солонгосын төв мэдээллийн агентлаг тус улсын түүхэн удирдагчдын тэмдэглэлт их баяр ирэх жилийн наймдугаар сард давхцан тохиохыг албан ёсоор мэдэгдэж, Пхеньянд ёслолын үйл ажиллагаа болно гэжээ. Тус сард Ким Ир Сены мэндэлсний 105 жил, Ким Жон Илын мэндэлсний 75 жил, Ким Жон Уны Хойд Солонгос улсыг удирдсаны таван жилийн тэгш ой тус тус давхцаж байгаа юм байна. Түүнчлэн энэ үеэр ирэх оны нэгдүгээр сарын 8-нд Ким Жон Уны төрсөн өдрийг улсын баяр болгон тэмдэглэхээр болсноо мэдэгдлээ. Дэлхийн хамгийн хаалттай улс болох Хойд Солонгос улсын төрийн тэргүүн хэдэн оны хэдэн сард төрсөн, эдүгээ хэдэн настай болох нь тодорхойгүй байдаг билээ.

# ГАИТИД 450 ГАРУЙ ХҮН АМИА АЛДЛАА



Б.ДАВАА

НҮБ-аас өнгөрсөн 20 жилийн хугацаанд тохиосон 7000 гаруй удаагийн байгалийн гамшигт үзэгдэлд дүн шилжилгээ хийсэн тайланг гаргалаа. Тайланд дурьдсанаар хамгийн хүчтэй газар хөдлөлт болсон Гаити улс дэлхийн улс орнууд дундаас хамгийн их хохирол амссан улсаар нэрлэгджээ. Гаитигийн өмнөд, хойд Америкийн хамгийн ядуу буурай орон болох тус улсад 2010 онд томоохон хэмжээний газар хөдлөлт болсноос хойш сэргээн засварлалт бараг хийгээгүй байсан юм. Гэвч энэ сарын эхээр мөн л далайн хар шуурга тус улсыг дайрч, ихээхэн хэмжээний хохирол учруулжээ. Карибын улс орнууд болон АНУ-ын өмнөд эргийн хотуудыг дайран өнгөрсөн Мэтью хар салхи АНУ-г ч дайрсан. Хамгийн сүүлд авсан мэдээгээр зөвхөн АНУ-д гэхэд л 10 хүн хар салхины үеэр амиа алдсан байна. Хэдийгээр орон нутгийн захиргаа онц байдал зарлаж, хоёр сая гаруй хүнийг нүүлгэн шилжүүлж, байгалийн гамшигт үзэгдэлд бэлтгэлтэй байсан боловч салхины хүч маш их байсан, их хэмжээний усархаг аадар бороо орж, хөрсний гулгалт үүссэний улмаас ийнхүү олон арван хүний амь нас сүйджээ. Шуурганы үеэр мод үндсээрээ булгаран унаж, ойролцоох байшин барилгуудыг дарж унаснаар дотор нь байсан хүмүүс дарагдаж амь насаа алджээ. Одоогийн байдлаар өмнөд эргийн хотууд болох Флорида, Жоржиа, Хойд Каролинад нэг сая гаруй айл өрх, албан байгууллага гэрэл цахилгаангүй болжээ.

Гэхдээ Гаити улсад дээрхээс ч илүүтэйгээр хохирол учирч, 470 гаруй хүн Мэтью хар салхины үеэр үүссэн үер болон хөрсний гулгалтын улмаас амиа алдсан аж. Мөн хэдэн зуун мянган хүн орон гэргүй болж, эрүүл ахуйн нөхцөл байдал муудсанаар холер өвчний уршгиар нас барсан тохиолдлууд ч сүүлийн хэд хоногт бүртгэгджээ.

Иймд нэн тэргүүнд тусламж хүртэх шаардлагатай байгаа Гаитигийн 750 мянга гаруй хүнд хоол хүнс, эм тариа, түр хоргодох майхан сав хэрэгтэй байгаа учир НҮБ-аас олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудад хандан тусламжийн бараагаа нэмэгдүүлэхийг уриалаад байна. НҮБ-ын тайланд дурьдсанаар 1996-2015 онд байгалийн гамшигт үзэгдлийн улмаас нас барсан 1.35 сая хүний 90 гаруй хувь нь бага, дунд орлоготой орнуудад амьдарч буй хүмүүс байсан бөгөөд тэр дундуу Гаитид зургаан хүн тутмын нэг нь гамшигт үзэгдлээр амиа алдаж байгааг онцолсон байв. НҮБ-ын Гамшгийн асуудал эрхэлсэн тусгай элч төлөөлөгч Роберт Глассер хэвлэлийн хурлын үеэр “Улс орны нийгэм эдийн засгийн байдал, тус улсын дайрсан байгалийн гамшигт үзэгдлийн улмаас хүн төрөлхтөнд учруулсан хохирол хоёрын хооронд тодорхой харилцан хамаарал бий” гэдгийг тодотгожээ. Харин сүүлийн 20 жилийн хугацаанд байгалийн үзэгдлийн улмаас амиа алдсан хүнийхээ тоогоор Индонез хоёрдугаарт бичигдэж байна. Индонезийн 182 мянга орчим хүн амь үрэгджээ. Харин гуравдугаарт Мьянмар эрэмбэлэгдэж байгаа бөгөөд тус улсад 139500 хүн үрэгдсэн байна.



## Токиог харанхуй нөмөрчээ

Японы нийслэл Токио хотод эрчим хүч тасарч, 580 мянган айл өрх гэрэл цахилгаангүй болжээ. Үүнээс үүдэн Токио хот даяар төрийн засаг захиргааны зарим байгууллагын үйл ажиллагаа доголдож, цахилгаан галт тэргүүд түр зогссон байна. Токио Эрчим хүчний компанийн мэдэгдэж байгаагаар ийнхүү хотын ихэнх бүсийг хамарсан эрчим хүчний доголдлын шалтгааныг тодруулахаар шалгаж байгаа аж. Токио хотын ойролцоох Низа хотын эрчим хүчний дэд станцид 35 жилийн өмнө газар доогуур татсан кабелийн утас шатсан нь энэ хэрэгтэй холбоотой байж болохыг шалгах шатандаа явж байна гэсэн юм. Токио хотын 580 мянган айл өрхийг гэрэл цахилгаангүй болгосон уг осол дамжуулагч кабель шатсантай холбоотой эсэхийг одоогийн байдлаар баталж чадахгүй байна. Учир нь эдгээр урт настай, эрчим хүч дамжуулах кабелуудыг ойр ойрхон шалгаж, доголдол гарсныг нь шинэчилдэг бөгөөд хамгийн сүүлд өнгөрсөн зургаадугаар сард шалгаж, хэвийн үйл ажиллагаатай гэж тогтоож байжээ. Одоогийн байдлаар ихэнх айл өрх гэрэл цахилгаантайгаа залгаад байгаа юм байна.

## Колумбичууд энхийн хэлэлцээрийг шаардан жагсав

Хагас зуун жил гаруй үргэлжилсэн иргэний дайныг эцэс болгохын тулд Колумбын Засгийн газар болон босогчдын бүлэглэл болох “ФАРК”-ийн хооронд байгуулсан энхийн гэрээг дагаж мөрдөхийг шаардан тус улсын нийслэл Богота хотод хэдэн мянган хүн жагсаал хийжээ. Энх тайвныг тогтоохыг бэлгэдэн иргэний дайны хохирогчдын ар гэрийнхэн жагсаалын үеэр цагаан цэцэг өгчээ. Олон жил хэлэлцээ хийсний эцэст байгуулсан энхийн гэрээг хэрэгжүүлэхийг өнгөрсөн сард тус улсад болсон бүх нийтийн санал асуулгад оролцогчдын талаас илүү хувь нь эсэргүүцсэн билээ. Уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх эсэхийг Колумбын ард иргэд шийдэх ёстой юм. Босогчидтой энхийн гэрээ байгуулсныг эсэргүүцэгчид энхийн гэрээний зарим заалтыг өөрчлөхийг шаардаж байгаа аж. Харин хэдэн мянган оюутан, тариаланчид болон нутгийн уугуул оршин суугчдын удирдагчид Богота хот дахь Конгрессын ордны өмнө цуглан уг гэрээг дэмжиж байгаагаа илэрхийлжээ. Дайны улмаас дүрвэсэн 64 настай Карменза Пинто ярихдаа “энх тайвныг тогтоохын төлөө Колумбын бүх иргэн ажиллах хэрэгтэй” гээд “сайн сайхан ирээдүйг бий болгохын тулд бид бүгдээрээ хичээн зүтгэх хэрэгтэй. Уучлал бол бидний үзүүлж чадах хамгийн том үлгэр жишээ” гэв. Газар өмчлөх эрхтэй холбоотойгоор 1960-аад оны үед Колумбын Засгийн газар болон “ФАРК” хооронд дэгдсэн зэвсэгт мөргөлдөөн 220 мянга орчим хүний аминд хүрч, зургаан сая хүнийг орон гэрээсээ дүрвэхэд хүргэжээ. Энхийн хэлэлцээр байгуулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлэн Колумбын Ерөнхийлөгч Хуан Мануэль Сантосыг Нобелийн Энх тайвны шагналтнаар тодруулсан билээ.

Тэрбээр Нобелийн шагналыг дагалдах найман сая крон буюу 925 мянган долларыг иргэний дайнд хохирсон хүмүүст туслахад хандивлахаа мэдэгдсэн юм.


“ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ ТАВТАЙ МОРИЛ



Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

**АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.**

Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхэдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО

Холбоо барих утас: 99094864

MMINFO.

# СПОРТ






КАРАТЭГИЙН ДАШТ-ЭЭС ГАНЗАГА ДҮҮРЭН ИРЛЭЭ

ОУИМ А.ЭНХТУУЛ ТАВДУГААР БАЙР ЭЗЭЛЖЭЭ

VIII нүүрт


ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ






# МАНАЙ ГИМНАСТИКЧИД МАНЖУУРААС 23 БАГЦ МЕДАЛЬ ХҮРТЭВ

Н.ЗАЯА

"Манжуур-2016" аэробик гимнастикийн олон улсын тэмцээн хоёр дахь удаагаа амжилттай болж өндөрлөлөө. Энэ удаагийн тэмцээнд ОХУ-ын муж, Дорнод сибирийн бүс нутгийн баг, БНХАУ, Монгол Улсын нийт 16 багийн 180 гаруй тамирчид таван насны ангилалд өрсөлдсөн байна. Тодруулбал, тамирчид 6-8, 9-11, 12-14, 15-17, 18-аас насны ангилалд эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан, хос, гуравласан, баг, бүжгийн баг, степний багийн төрөлд өрсөлдөж, шилдгээ шалгаруулжээ. Тус тэмцээнд манай улсын таван багийн 48 тамирчин, 11 албаны хүний бүрэлдэхүүнтэйгээр анх удаагаа оролцсон юм. Тэмцээний нээлтийн ажиллагаанд БНХАУ-ын МанжуурхотынБиеийнтамирспортын хорооны дарга Вү Ли, ОХУ-ын Чита хотын биеийн тамир спортын хорооны дарга В.А.Сергеевич, Монголын гимнастизийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Г.Ерөөлбат нар оролцлоо. Энэхүү тэмцээнд багийн дүнгээр 1-р байрт ОХУ-ын Чита хотын баг, 3-р байрт ОХУ-ын Эрхүү хотын баг тамирчид шалгарчээ. Харин манай баг, тамирчид нийт 35 багц медалиас 23 медаль хүртсэн амжилтаар 2-р байрт шалгарсан аж.

Тодруулбал, эрэгтэй ганцаарчилсан төрөлд Г.Идэржавхлан мөнгө, хосын төрөлд Ч.Батбуян, Н. Болор нар мөнгө, Степний багийн төрөлд Г.Идэржавхлан, Ч.Батбуян, Н. Болор, Б.Анужин, Б.Саруул, С. Номинжин, Г.Хишигжаргал, Э. Халиунаа нар мөнгөн медаль хүртжээ.

Мөн 12-14 насны ангиллын эмэгтэй ганцаарчилсан төрөлд Ж.Азжаргал мөнгө, эрэгтэй ганцаарчилсан төрөлд Н.Баян-Эрдэнэ Алт, Б.Оргилболд мөнгө, У.Амарсайхан хүрэл, хосын төрөлд Н. Баян-Эрдэнэ, Б.Ариунзул алт, У.Амарсайхан, Б.Номин нар мөнгө, Д.Тэмүүлэн, Э.Номинтуяа нар хүрэл, бүжгийн багийн төрөлд Н.Баян-Эрдэнэ, Б.Ариунзул, Ж.Азжаргал, Б.Отгонзул, Б.Анхбаяр, Э.Минжбадгар, М.Хонгорзул, Э.Отгондорж нар мөнгөн медаль, Степний багийн төрөлд Н.Баян-Эрдэнэ, Б.Ариунзул, Ж.Азжаргал, Б.Отгонзул, Б.Анхбаяр, Д.Тэмүүлэн, Э.Номинтуяа, Б.Мөнхсайхан нар хүрэл медаль хүртсэн гэнэ.

Харин 15-17 насны ангилалд М.Бямбацэнд эмэгтэй ганцаарчилсан төрөлд алт, Б.Хонгорзул, Б.Номинзул, Т.Болор нар гуравласан төрөлд алт, Б.Хонгорзул, Б.Номинзул, Т.Болор, М.Бямбацэнд, Н.Хулан нар багийн төрөлд алт, бүжгийн багийн төрөлд Х.Урангоо, Б.Энхзул, Г.Анударь, Т.Гантуяа, Ө.Ганцацрал, Э.Энхмаа, Н.Нямдаваа, Э.Батзориг нарт алт, степний багийн төрөлд Х.Урангоо, Б.Энхзул, Г.Анударь, Т.Гантуяа, Ө.Ганцацрал, Э.Энхмаа, Н.Нямдаваа, Э.Батзориг нарт алтан медаль хүртсэн амжилтыг гаргажээ.

Түүнчлэн насанд хүрэгчдийн ангилалын эмэгтэй ганцаарчилсан төрөлд С.Дэлгэрмаа алт, эрэгтэй ганцаарчилсан төрөлд Г.Сэргэлэн алт, хосын төрөлд Б.Золбаяр, Б.Ичинхорлоо алт, гуравласан төрөлд Т.Оюундарь, Х.Содчимэг, Г.Саранцацрал нар алт, багийн төрөлд Г.Болортулга, Б.Өлзийжаргал, Б.Золбаяр, Г.Сэргэлэн, Б.Ичинхорлоо нар алт, бүжгийн багийн төрөлд Б.Өлзийжаргал, Б.Золбаяр, Б.Ичинхорлоо, Т.Оюундарь, Х.Содчимэг, Г.Саранцацрал, С.Дэлгэрмаа, М.Солонго нар алтан медаль тус тус хүртсэн байна.

## Үндэсний супер лиг ирэх сарын 4-нд эхэлнэ

Монголын Үндэсний сагсан бөмбөгийн холбооноос ирэх арваннэгдүгээр сард 21 аймгийн "Үндэсний супер лиг"-ийн тэмцээнийг зохион байгуулна. Зөвхөн эрэгтэй багуудын дунд болох уг тэмцээнд 17 аймгийн баг оролцохоор бүртгүүлж, хоёр бүсэд хуваагдлаа. Тэмцээн арваннэгдүгээр сарын 4-нд эхэлж, 2017 оны хоёрдугаар сард дуусах юм. Ингээд багуудыг хуваарийг танилцуулъя.

**БҮСИЙН ХУВААРИЛАЛТ**
**БАРУУН БҮСИЙН АЙМГУУДЫН БАГУУД:**

Завхан
Орхон
Архангай Golden East Warriors
Булган Legacy
Өвөрхангай
Хөвсгөл
Ховд Алтайн Аргаль
Баянхонгор
Увс

**ЗҮҮН БҮСИЙН АЙМГУУДЫН БАГУУД:**

Дархан Гарьд
Дорнод
Дорноговь
Сүхбаатар Альянс Тех Харцага
Төв Ургац
Хэнтий ЭБЭГ Хасу мегаватт
Сэлэнгэ
Өмнөговь

## Монгол залуус Солонгост дугуйтай аялна



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

БНСУ-ын Бусан хотын эрүүл мэнд, аялал жуулчлалын өдөрлөг өнгөрсөн амралтын өдрүүдэд Улаанбаатар хотод болж өндөрлөлөө. Энэхүү өдөрлөгийн хүрээнд Улаанбаатар Бусан хотын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх хэд хэдэн ажил хэрэгч уулзалт болсон бөгөөд эрүүл мэнд, аялал жуулчлалын чиглэлээр Улсын клиникийн 1-р эмнэлэг, Монголын аялал жуулчлалын холбоо зэрэг холбогдох байгууллагууд хамтран ажиллахаар тохиролцов. Тухайлбал, "МВ" Олон улсын унадаг дугуйн аяллын холбооны залуус Бусаны талтай тохиролцсоны дагуу БНСУ-ын хотуудаар 660 гаруй км үргэлжлэх дугуйн аяллыг анх удаа хийхээр боллоо. Энэхүү аялал гараагаа Сөүл хотоос эхэлж, Бусанд барианд орох бөгөөд Олон улсын унадаг дугуйн холбооны гишүүн 21 дугуйчин аялалд гарна. Аяллын зохион байгуулагчаар "МВ" олон улсын унадаг дугуйн аяллын холбоо, "Merida Mongolia" унадаг дугуйн дэлгүүр, ивээн тэтгэгчээр "Айр Бусан" ХХК, "Merida Mongolia", "Shimano Mongolia", "Хүнс комплекс" ХХК, "Khuvsgul lake" зочид буудал, "Merida Mongolia" унадаг дугуйн клуб ажиллаж байна. Монгол залуусын энэхүү дугуйтай аялал эх орноо, Улаанбаатар хотоо сурталчлах, эрүүл мэндээ хамгаалахыг уриалахад оршиж байгаа ажээ. Сонирхуулахад, Улаанбаатар-Бусаны хооронд өнгөрсөн 6 дугаар сараас "Айр Бусан" авиа компани долоо хоногт хоёр удаа шууд нислэг үйлдэж байгаа юм. Юутай ч, Монголын унадаг дугуйтай 21 залуу Солонгосыг байлдан дагуулах нь ээ.

ХӨЛБАМБӨГИЙН ЭРГЭН ТОЙРОНД



## Мессигүй Аргентин хожигдлоо

Хөлбөмбөгийн ДАШТ-ий Өмнөд Америкийн бүсийн урьдчилсан хэсгийн тоглолтууд явагдлаа. Лео Мессигээ гэмтэлд "алдсан" Аргентины шигшээ баг талбайдаа Парагвайд 0:1 харьцаагаар хожигджээ. Аргентины шигшээ баг одоогийн байдлаар бүсдээ тавдугаар байрт бичигдэж байна. Тэдний дараагийн учраа Уругвай бөгөөд дараа жилийн гуравдугаар сард тоглох хуваарьтай байна. Машерано "Бид маш хүнд байдалд байна. Бид гэрэл олж харахгүй байна. Урьдчилсан шатанд бид оноо алдсаар байна. Тэр бидэнд хэрэгтэй байна гэсэн бол" Анхел Ди Мариа "Түүнийг энд байхгүй үед бүр хэцүү болох юм. Бүр маш хэцүү. Чи түүнд бөмбөг өгвөл тэр тоглолтыг шийддэг" хэмээжээ. Харин Мартин Демичилес "Бид Мессигүйгээр юу ч биш юм байна" гэжээ.

## "Челси" Доннаруммаг сонирхож эхэлжээ

Английн "Челси" клуб "Милан"-ы хаалгач Жанлуижи Доннаруммаг энэ улирлын төгсгөлд авахыг хүсч байгаа ажээ. Түүнээс гадна "Реал" болон "Ювентус" клубүүд ч түүнийг сонирхож байгаа юм. Corriere dello Sport-ийн мэдээлж байгаагаар сүүлийн хэдэн сар Италийн багийн 17 настай хаалгачийн үнэ 40 саяас 70 болж нэмэгдээд байгаа аж. Энэ сарын 25-ны өдөр тэрбээр 18 нас хүрэх бөгөөд "Милан" клуб гэрээгээ сунгах тал дээр ч ажиллаж байгаа юм байна.

## Майкл Каррик дасгалжуулагч болохоор төлөвлөж байна

Английн алдарт "Манчестер Юнайтед"-ын шилдэг хагас хамгаалагчдын нэг Майкл Каррик хөлбөмбөгийн пүүзээ тайлж, дасгалжуулагч болохоор төлөвлөж байгаа ажээ. Шигшээ багуудын тоглолт үргэлжилж, лиг түр завсарласан өдрүүдэд тэрбээр Европын хөлбөмбөгийн холбооны дасгалжуулагчийн А лицензийг авахаар суралцаж байгаа юм байна. Энэ талаараа тэрбээр өөрийн албан ёсны инстаграм хуудсаар дамжуулж мэдээлжээ.

## Лейкэрс нэмэлт цаг Портлэндэд хожигдлоо

NBA-ын шинэ улирал эхлэхэд 14хоног үлдээд байгаа бөгөөд улиралын өмнөх тоглолтууд явагдаж байна. Энэ улирлыг шинэ дасгалуулагч болох Лук Уолтонтой эхлүүлж байгаа Лос Анжелес Лейкэрс талбай дээрээ Портлэнд Трэйл Блэйзэрс багтай тоглолоо. Тоглолтын эхний хагаст 50-50 харьцаатай дуусч энэ тэнцүүхэн өрсөлдсөн бол сүүлийн хагаст мөн адил өрсөлдөж 99-99 харьцаагаар тэнцжээ. Нэмэлт цагт сүүлд Лейкэрс гурван оноогоор хожигдож байхдаа тэнцүүлэх шидэлтийг Жордан Кларксон хийсэн ч амжилтгүй болж 106-109 харьцаагаар улирлын өмнөх тоглолтын хоёр дахь ялагдлаа хүлээлээ. Харин Портлэндийн хувьд гурван ялалттай ганц хожигдолгүй байна. Тус тоглолтод Диман Лилард 27 минут тоглохдоо 30 оноог авч бүх тоглогчдийг тэргүүлсэн бол Плампи 11 оноо, 11 самбараас бөмбөг авч тусалжээ. Харин эсрэг багаас Жордан Кларксон 15 оноог авч багаа тэргүүлсэн бол Ди Анжело Рассел 12 оноог авчээ. Тэрбээр холын зайнаас есөн удаа шидээд ганцыг нь ч оруулаагүй байна.

# СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН

## Каратэгийн ДАШТ-ээс ганзага дүүрэн ирлээ



Н.ЗАЯА

Каратэгийн сонирхогчдын дэлхийн аварга шалгаруулах гурав дахь удаагийн тэмцээн өнгөрсөн сарын 30-наас энэ сарын 2-ныг хүртэл Грекийн нийслэл Афин хотод амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнд манай улсаас Монголын Шинкёкушинкай Каратэгийн Холбооны "Очир нударга тулааны төв", " Challenged fight" клубын зургаан тамирчин оролцсон юм. Тодруулбал, эрэгтэйчүүдийн 75 кг-д Ө.Саруул-Од, эмэгтэйчүүдийн 60 кг-д Д.Ганболор, 70 кг-д Ө.Төрбаяр, 77 кг-д Б.Наадам, 65 кг-д О.Лхасүрэн, 75 кг-д Ч.Баатарсүрэн нар оролцжээ. Манай улсын баг тамирчдын үзүүлсэн амжилт, ур чадварыг тэмцээн зохион байгуулагчид болон Олон улсын каратегийн холбооны удирдлагууд өндрөөр үнэлсэн байна. Энэхүү тэмцээн нь мэргэжлийн тулааны спортын ертөнцөд хамгийн нэр хүнд бүхий тэмцээнүүдийн нэг болох К-1-ийн дүрмээр зохион байгуулагддагаараа онцлогтой ажээ. Дашрамд сонирхуулахад, Шинкёкушинкай каратэгийн холбоо манай улсад байгуулагдаад хоёр жил болж байгаа гэнэ. Ингээд тамирчдын амжилтыг дэлгэрэнгүй танилцуулъя.

**Эмэгтэйчүүдийн**
-60кг-ын жинд спортын мастер Д.Ганболор алтан медаль,
**Эрэгтэйчүүдийн**
-65кг-ын жинд ОУХМ (олон улсын хэмжээний мастер) О.Лхасүрэн мөнгөн медаль,
-70кг-ын жинд ОУХМ Ө.Төрбаяр мөнгөн медаль,
-77кг-ын жинд ОУХМ Б.Наадам мөнгөн медаль,
**Ахмадын**
-75кг-ын жинд ОУХМ Ө.Саруул-Од алтан медаль,
ОУХМ Ч.Баатарсүрэн хүрэл медаль тус тус хүртэж , өндөр амжилт үзүүллээ.







МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## "Мастерс"-ын ДАШТ-д долдугаар байр эзлэв

Чөлөөт бөхийн ахмад тамирчид аравдугаар сарын 7-9-ний өдрүүдэд Польшийн нийслэл Валбжих хотноо "Мастерс"-ын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдлөө. Тус тэмцээнд Монголоос 11 тамирчин оролцсон бөгөөд 58, 63, 69, 75, 85, 97, 130 кг-ын жинд A, B, C, D, E, F, G гэсэн насны ангилалд тэмцээнийг зохион байгуулжээ. Монголын тамирчид "Мастерс" ангиллын ДАШТ-ээс хоёр алт, гурван мөнгө, зургаан хүрэл, нийт 11 медаль хүртэж, 37 орны багаас VII дугаар байрт шалгарсан байна.

## ОУИМ А.Энхтуул тавдугаар байр эзэлжээ



Англи улсад болсон олон улсын өндөр чансаатай шатарчдын "Isle of Man" нээлттэй тэмцээнд оролцсон ОУИМ А.Энхтуул тавдугаар байрт шалгарчээ. Их мастер А.Энхтуул нийт есөн өргөөс таван оноо авч өөрийн олон улсын чансаагаа 30 оноогоор ахиулжээ. Тэрбээр эмэгтэйчүүдийн тавдугаар байрын шагналыг шатрын Дэлхийн аварга, Хятадын шатарчин, супер их мастер Хоу И Фань тэргүүтэй шилдэг шатарчдын хамт эзэлсэн байна. Тэмцээнд нийт 39 орны эрэгтэй, эмэгтэй 132 шилдэг шатарчин оролцжээ.

## "Хоромхон" клубийг таван сая төгрөгөөр торгохоор боллоо

Монголын Хөлбөмбөгийн Холбооны цом 2016 тэмцээний өнгөрсөн даваа гарагийн 15:00 цагийн хагас шигшээ тоглолт болох "Дэрэн" болон "Хоромхон" багуудын тоглолтын үеэр Хоромхон багийн зарим тоглогчид болон албаны хүмүүс шүүгчийн бүрэлдэхүүнийг хэл амаар доромжилж, спортын бус авир гаргасан байна. Тухайлбал, Хоромхон багийн эмч Н.Болор-Эрдэнэ нь талбайн 1-р туслах шүүгч Т.Галдансүхийн биед нь ноцтойгоор халдсан нь баримтаар нотлогдож байгаа тул Монголын Хөлбөмбөгийн Холбооны Онцгой байдлын хороо өнгөрсөн мягмар гарагт хуралдаж дараах шийдвэрийг гаргажээ. Тодруулбал, Хоромхон клубыг "Холбооны цом 2016" тэмцээнээс хасч таван сая төгрөгөөр торгох шийтгэлийг ногдуулсан байна. Мөн багийн эмч Н.Болор-Эрдэнэд хөлбөмбөгтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанд оролцох эрхийг 24 сараар хасч гурван сая төгрөгөөр торгосон аж.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 9
Шөнө 3

Нөгөөдөр
Өдөр 2
Шөнө -5

### Өдрийн зурхай

**Намрын адаг шар нохой сарын Найман цагаан мэнгэтэй Шарагчин могой өдөр. Сугар гараг**

**Үс засуулбал:** Жаргал ирнэ
**Наран ургах, шингэх:** 07:13 - 18:17



*Өдрийн өнгө: Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сан тавиулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.*

